



Published in the Russian Federation
Bulletin of the Kalmyk Institute for Humanities
of the Russian Academy of Sciences
Has been issued since 2008
ISSN: 2075-7794; E-ISSN: 2410-7670
Vol. 28, Is. 6, pp. 122–127, 2016
DOI 10.22162/2075-7794-2016-28-6-122-127
Journal homepage: <http://kigiran.com/pubs/vestnik>

UDC 398.224

The Epic of *Jangar*: General Research Data on the Bayangol Version (1980–2000s)

Bayantalya Tergel¹

¹MA Student, Institute of Mongol Studies, Inner Mongolia University (Hohhot, People's Republic of China). E-mail: Ananda1015@163.com

Abstract. The article aims to give an overview of research papers dealing with the Bayangol version of the Jangar epic, and offer basic insights into their contents. For that, the following tasks were tackled: 1) the issue of each certain jangarchi (Mong. 'Jangar performer/singer') and peculiarities of epic studies (methods) conducted, including those exploring materials recorded from Bayangol Mongols; 2) to clarify the research methods for the investigation of performance styles and skills typical for each certain jangarchi; 3) to compare viewpoints of scholars to have studied the epic tradition of Jangar. The comparative analysis of works by well-merited Jangar explorers to have dealt with the still living epic tradition of Xinjiang Mongols, who have been able to preserve it to the present days, makes it possible to judge about the current state of the Jangar performance tradition among the native inhabitants of Bayangol, and make conclusions how deeply the considered papers explore the issue. It is generally believed that the Jangar epic performance tradition exists – and is handed down from generation to generation – in Mongolic populations, but each region (Mong. *nutag*) has its distinctive features. So, in view of all this, exploration of the Jangar tradition inherent to Bayangol inhabitants of Xinjiang, the history of its studies in academic works proves an important trend in epic studies.

Keywords: Oirats, Xinjiang, Bayangol, Jangar studies

Аман уламжлалын охь шим болсон Монголчуудын баатарлаг тууль «Жангар» нь эртнээс нааш одоог хүртэл дэлхийн олон улс орны эрдэмтдийн анхаарлыг татан улам бүр өргөжин хөгжиж байгаа нэгэн судалгааны сэдэв болно. «Жангар» туулийн анхны хэсгүүдийг 1804 онд Германы эрдэмтэн Б. Бергман Халимагаас илрүүлэн, түүнийгээ герман хэлээр орчуулан тайлбартайгаар хэвлүүлсэн юм. Түүнээс хойш Монгол, Орос, Герман, Америк, Япон зэрэг олон орны эрдэмтэд энэхүү туулийг олон талаас

нь судалсан боловч одоо болтол түүний нууцыг бүрэн нээж чадаагүй байна. 1910 оны орчимд Оросын эрдэмтэн В. Л. Котвич тэмдэглэн авч хэвлүүлсэнээс хойш Монгол, Халимаг, Хятадын Шинжааны өөрөө засах орны нутгаас олон арван бүлгүүд олджээ. Одоо «Жангар» туулийн Халимаг, Шинжаан, Монгол гэсэн үндсэн гурван хувилбар байгаа бөгөөд үүнд Монголд 20 орчим бүлэг, Халимагт 30 орчим бүлэг, Шинжаанд 70 орчим бүлэг мэдэгдээд байгаа билээ.

«Жангар» туулийн судлал үүсч хөгжөөд хоёр зуу шахам жил болж байгаа тул цуглуулж, судлах ажилд нэлээд ахиц гаран нарийвчлан шинжлэх болсон бөгөөд түүний уламжлалын томоохон хэсэг болох Шинжаан дахь «Жангар»-ын талаар улам гүнзгийрүүлэн судалбал «Жангар» судлалын тулгамдсан цөөнгүй асуудлыг шийдвэрлэж чадах нь лавтай.

Зөвхөн улсын дотоодод жил бүр нийтлэгдэж байгаа «Жангар» судлалд холбогдох өгүүлэл, зохиолын тооны хувьд Шинжааны «Жангар»-ын тухай өгүүлсэн бүтээл туурвил нь нилээд хувийн жинг эзэлж байгаа юм. Үүний дотор Шинжааны аль нэгэн аймаг, хошуудын жишээн дээр «Жангар»-ын уламжлал, ёс заншлыг тусгайлан сэдэвчилсэн судалгаагаа өрнүүлж байгаа нь цөөнгүй. Ийм учраас тус бяцхан өгүүлэлдээ XX зууны наяд оноос XXI зууны эхэн үе хүртэлх Шинжааны Баянголын «Жангар», жич жангарчдын тухай судалгаанд холбогдох өгүүлүүдийг тоймлон өгүүлье.

XX зууны наяд оноос XXI зууны эхэн үе хүртэлх Баянголын «Жангар», жич жангарчдад холбогдох өгүүлэл, зохиол нийтдээ 18 байгаа нь БНХАУ дахь «Жангар»-ын талаарх нийт судалгааны бүтээлүүдийн багагүй хувийг эзэлж байгаа юм. Эдгээр өгүүллийн зохиогчид нь цөм эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан бөгөөд голлон судлаж буй 9 хүн байгааг тэмдэглэж болно. Хэвлэгдсэн хэл, үсэг бичгийн хувьд тэдгээрийн 14 өгүүлэл нь монголоор бичигдэж, 4 өгүүлэл нь хятадаар бичигдсэн байна. Сэтгүүлийн хувьд хятад, монгол нийт 8 сэтгүүлд нийтлэгдсэнээс хамгийн олон өгүүлэл нийтлэгдсэнээр нь эрэмбэлэвэл «Баруун монгол судлал» сэтгүүл, «Хэл ба орчуулга» сэтгүүл, «Үүрийн цолмон» сэтгүүл зэрэг гурван сэтгүүлийг тэргүүнд нь дурьдахад хүрнэ.

Эдгээр Шинжааны Баянголын «Жангар»-ын судалгааны өгүүлэл зохиолын байдлыг агуулгаар нь жангарчид хийгээд «Жангар»-ын судлал, хайлах хэв намба хийгээд хэлбэр маягийн судлал, уламжлагдан хадгалагдсан байдлын судлал хэмээх 3 хэсэгт хуваан өгүүлье.

Жангарчид хийгээд «Жангар»-ын судлал

Аман уламжлалын залгамжлагч болсон жангарч нь «Жангар» судлалын хүрээн дэх бас нэг чухал судалгааны цэг болох юм. Цаашид жангарчдын хайлсан «Жангар» нь ч гол судалгааны цэг болох нь дамжиггүй.

Баянголын жангарч хийгээд «Жангар»-ын судлалд холбогдох нийт 9 өгүүлэл бий. Эдгээр тус бүрийг дэлгэрэнгүй дурьдвал, юуны өмнө Ринчендоржийн «Шинжааны „Жангар“ хийгээд жангарчдын тухай» хэмээх тод монгол үсгээр нийтлэгдэн нийтийн хүртээл болсон [Ринчендорж 1984а: 14–36] өгүүлэлд ерөнхийдөө Шинжаан дахь монголчуудын дунд уламжлагдан ирсэн «Жангар» тууль болон жангарчдын тухай өгүүлсэн бөгөөд түүний хүрээнд Баянголын жангарчид хийгээд «Жангар»-ын тухай хамрагдсан байна. Улмаар Ж. Ринчендорж нь дээр дурьдсан өгүүлэлээ монгол бичгээр хөрвүүлж Өвөрмонголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлд [Ринчендорж 1984б: 23–48] хэвлүүлсэн байна. Тус өгүүлэлд дээд дурьдсан ёсоор Баянголын жангарчид болон «Жангар»-ын тухай судалгаа томоохон хэсгийг нь хамарч байгаа билээ.

Х. Алтаны «Торгууд жангарчдын тухай дөхөм өгүүлэх нь» [Алтан 1998: 3] хэмээх өгүүлэлээ Шинжааны өдрийн сонинд хэвлүүлсэн бөгөөд үүндээ Баянголын торгууд жангарчдын тухай тусгайлан өгүүлсэн байна. Х. Алтан нь мөн дээрх өгүүлэлээ шинэчлэн найруулж «Торгууд жангарчдын тухай танилцуулга» [Алтан 1998: 48–50] гэсэн нэрээр Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан сэтгүүлд хэвлүүлсэн байна. Тус өгүүлэлд Шинжааны нийт торгууд жангарчид, түүний дотор Баянголын торгууд жангарчдын тухай ихээхэн нарийвчилж тусгасан билээ.

Харин судлаач Т. Надмайн «Жангарч Л. Пүрэвийн дөхөм танилцуулга» [Надмай 1999: 46–47] гэх өгүүлэлд Баянголын жангарчдыг бүхэлд судлаж тодруулах зорилго тавиагүй бөгөөд зөвхөн дан ганц Л. Пүрэв тусгайлан судласан судалгааны үр дүнгээсээ танилцуулан өгүүлсэн юм.

Д. Шагайн «Жангарын туулийг цуглуулах явцад хувь нэмрээ өргөсөн жангарчдын тухай өгүүлэх нь» [Шагай 1999: 48–53] хэмээх өгүүлэлдээ нийт орны хэмжээн дэх «Жангар туулийн» судалгааны явцыг өгүүлсэн боловч түүний дотор Шинжааны «Жангар»-ыг хайн цуглуулахад хувь нэмрээ үзүүлсэн Баянголын жангарчдын тухай тусган өгүүлсэн байна.

Нарсын «Баянголын орчин үеийн жангарчдыг туршин өгүүлэх нь» хэмээх тод монгол үсгээр [Нарс 1999: 16–24] Ойрадын судлал сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэлдээ Шинжааны Баянголын орчин үеийн жан-

гарчдын тухай танилцуулан өгүүлэх зорилго тавиад түүнийгээ хангалттай биелүүлж, сонирхогч олон түмэнд Баянголын эдүгээ цагийн жангарчдыг оновчтой танилцуулж чадсан билээ.

Д. Таяагийн «XX зууны үеийн Шинжааны ойрдын жангарчдын эгнээ» [Таяа 2003: 85–91] нэрээр «Үүрийн цолмон» сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлд мөн л дээрх Нарсын өгүүлэлтэй ойролцоо үр дүнг харуулж XX зууны үед нэр алдраа нутаг усандаа дуурсган жангар туулиа хайлж байсан Баянголын жангарчдыг танилцуулан дурьджээ.

Эцэст нь Ринчиндоржийн «Шинжааны „Жангар“ болон жангарчдын тухай» [Ринчедорж 1984б: 23–48] хэмээх өгүүлэлд Шинжаанд 1980 онд үүсгэн санаачлагдсан «Жангар» судлалын болон «Жангар» туулийг эмхэтгэн цуглуулах дугуйлангуудын өрнүүлсэн судалгааны ажлын үр дүнгүүдийг нийтийн хүртээл болгон танилцуулсан юм. Ийнхүү «Жангар» судлалыг эрчимжүүлэх зорилгоор байгуулагдсан тус хоёр дугуйлангаас удирдан зохион байгуулж 1980 оны 3 дугаар сараас 1981 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд монгол үндэстэн төвлөрөн сууж байгаа 12 аймаг, хошуу, хот, тосгонд хээрийн судалгаа хийж олон төрлийн аман уламжлалаархадгалагдан өвлөгдсөн «Жангар»-ыг цуглуулсан байна. Үүний хүрээнд 1981 оны 6 дугаар сараас 7 дугаар сарын хооронд урьд өмнө явагдаж байгаагүй «Жангар» хайлах уралдаан зохион байгуулж, Баянгол болон Тарвагатайд «Жангар» судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал, зөвлөгөөн хийж, түүнд оролцсон олон жангарчдын хайлах явцыг дүрс, дуу бичлэгээр хадгалан авсан тухай зэрэг олон сонирхолтой асуудлын талаар дурьдсан байна.

Хураангуйлвал, XX зууны 80-аад оноос XXI зууны эхэн үе хүртэлх хугацаанд Баянголын жангарч хийгээд «Жангар»-ын судлал нь гол төлөвхөн нэгэн нэртэй жангарчийн танилцуулга болон «Жангар» туулийн бичвэрийн цуглуулгад төвлөрөн анхаарч байсан байна.

Хайлах хэв намба хийгээд хэлбэр маягийн судлал

Жангарч бол «Жангар»-ын уламжлан залгамжлагч, хадгалан үлдээгч мөртлөө үүдэн бүтээгч мөн [Таяа 2012: 21–27] гэдэг үзэл санааны дагуу аман уламжлалын өв залгамжлагч, уламжлагч болсон жангарчийн судлалд жангарчийн хайлах хэв намба, хайлах хэлбэр маягийн асуудал ч хол-

богддог. Түдэвийн Жамцын «Ойрад жангарчид хийгээд тэдний жангар хайлах хэв намба» [Жамц 1989: 32–42] гэх өгүүлэлд Шинжааны Баянголын жангарчдын «Жангар» хайлах хэв намбын талаар танилцуулан өгүүлсэн байна.

Улмаар Д. Таяагийн «Шинжааны ойрад жангарчдын хэв намбын асуудалд» [Таяа 2005: 37–45] хэмээх нэрээр «Хэл ба орчуулга» сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлд Баянгол зэрэг Шинжааны монгол жангарчдын хайлах хэв намбын тухай өөрийн үзлээ судалгаандаа тулгуурлан дэлгэрүүлж дурьдсан байна.

Т. Баатарын «Жангарч Ням хийгээд түүний хэлсэн „Жангар“-ын хэв намба» [Баатар 2010: 104–111] гэсэн нэрээр «Баруун Монгол судлал» сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэлд Баянголын жангарчдын дундаас жангарч Нямыг тухайлан танилцуулж, түүний «Жангар» хайлах хэв маягийн тухай ч өгүүлжээ.

Жангарчийн «Жангар» хайлах хэлбэр маягийн талаар Д. Таяа «Шинжааны жангарчдын „Жангар“ хайлах, хэлбэр маягийн тухай» [Таяа 2006: 108–113] хэмээх «Ойрадын судлал» сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлдээ Баянгол зэрэг эл газар орны жангарчдын «Жангар» хайлах хэлбэр маягийн талаар танилцуулахын хамт хайлах хэлбэр маягийн тухай өөрийн үзэлтээ дурьдсан байна.

Хураангуйлвал, XX зууны 80-аад оноос XXI зууны эхэн хүртэлх хугацаанд эрдэмтдээс Баянголын жангарчдыг тусгайлан танилцуулж, тэдний «Жангар» хайлах хэв намба болон хэлбэр маягийн тухай шинжлэн өгүүлэхийн хамт өөрийн үзэлтээ дурьдсан судалгааны өгүүлэл цөөнгүй байна. Энэхүү жангарчдын «Жангар» хайлах хэв намба болон хэлбэр маягийн тухай судалгаа гүнзгийрсэн явдал нь «Жангар» судлалын хир түвшинг улам нэг алхам ахиулсан байна.

Уламжлалын судлал

«Жангар» нь зөвхөн Монгол төдийгүй Түрэгийн зарим овог ястны дунд ч аман уламжлал ба бичгийн уламжлалын хэлбэрээр одоог хүртэл уламжлагдсаар ирсэн түүхэн урт замналын тодхон мөртэй юм. Ийм учраас «Жангар» судлалын чухал нэг сэдэв бол даруй түүний тархалт, хадгалалтын асуудалд холбогдоно.

Т. Жамцын «Шинжааны ойрад монголын баатарлаг тууль „Жангар“-ын тархалт ба түүний хадгалалтын тойм байдал» [Жамц

1985: 353–369] хэмээх тод монгол үсгээр хэвлэгдэн нийтийн хүртээл болсон өгүүлэлд Баянголын «Жангар»-ын тархалт болон хадгалалтын талаар тоймлон өгүүлэв. Улмаар Т. Жамцын «Шинжаанд „Жангар“-ыг хайн шинжилж байгаа нь» [Жамц 1985: 84–89] гэх өгүүлэлд Баянгол дахь «Жангар»-ын тархалтын тухай дэлгэрүүлэн өгүүлсэн бол мөн түүний «Монгол үндэстний баатарлаг тууль «Жангар»-ын байцаалтын мэдүүлэлт» [Жамц 1982: 62–68] хэмээх өгүүлэлд ч Баянгол дахь «Жангар»-ын тархалтын байдлыг мэдээлжээ.

Т. Жамцын ойрад монголчуудын дундах „Жангар“ хадгалалтын байдал [Жамц 1985: 353–369] хэмээх өгүүлэлд 1980 онд Шинжааны уйгур үндэстний өөртөө засах орны Баянголын Монгол үндэстний өөртөө засах аймаг, Борталын Монгол үндэстний өөртөө засах аймаг болон Ховог сайрын монгол үндэстний өөртөө засах хошуу зэргээр төвлөрүүлэн анх удаагаа «Жангар» хайлах хурлыг эрхлэн явуулахын зэрэгцээгээр «Жангар»-ын 67 бүлэг, 40 гаруй хувилбарт дуу бичлэг хийж хадгалан судалж байгаа талаар өгүүлсэн байна.

Загарын «Дундад улс дахь „Жангар“-ын бар хэвлэлийн уламжлал жич, судалгааны байдлын товчлол» [扎格尔 1994: 71–76] гэх өгүүлэлд БНХАУ-ын дотоод дахь «Жангар»-ын эмхэтгэн цуглуулах ажлын байдал, өөр хоорондоо адилгүй арван нэгэн бар хэвлэлийн үндсэн байдал болон онцлогийн тухай оновчтой үнэлж, манай улсын «Жангар» судлах газрын адил бус цаг үе үд дэх түүхэн замнал болон одоогийн байдлыг хураангуйлан тавьсан байна.

Хураангуйлвал, «Жангар»-ын уламжлалын судлалын талаар XX зууны 80-аад оноос ХХI зууны эхэн хүртлэх хугацаанд Шинжааны монгол үндэстэн төвлөрөн сууж байгаа дээрх аймаг, хошууд дахь «Жангар»-ын тархалт болон хадгалалтын байдал адил бус төдийгүй хэвлэлийн уламжлалын байдал, Дундад улсын «Жангар» судлах газрын түүхэн замнал ба өнөөгийн байдлыг хураангуйлан өгүүлэхээр асуудлыг голчлон анхаарч ирсэн байгааг олж харж болно.

ХХ зууны 80-аад оноос ХХI зууны эхэн үе хүртлэх хугацаан дахь Шинжааны Баянголын «Жангар» судлалын өгүүлэл зохиолуудын тоймоос харахад голдуу жангарчийн танилцуулга, «Жангар» хайлах хэв намба хийгээд хэлбэр, «Жангар»-ын уламжлалын судалгаа гэх зэрэг талаас түлхүү хамруулан судласан байна.

Гэхдээ эдгээр судалгааны бүтээлүүдээс харахад Баянголын «Жангар» ба жангарчдын тусгайлан судласан өгүүлэл зохиол бас ч дутмаг байна гэж үзэж болно. Тэр мөртлөө эдгээр өгүүлэл зохиолуудын шинжлэх ухааны түвшин нь тэр бүр хангалттай түвшинд хүрээгүй бөгөөд эх хэрэглэгдэхүүний талаар уран зохиолын уншлагын текстийг ашиглах мэтийн бага сага дутагдалтай талууд оршиж байна хэмээн дүгнэж байна.

Литература

- Алтан Х. Торгууд жангарчдын тухай дөхөм өгүүлэх нь // «Шинжааны өдрийн сонин». 1998. 3 сар. С. 3.
- Алтан Х. Торгууд жангарчдын тухай танилцуулга // «Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан» сэтгүүл. 1998. № 6. С. 48–50.
- Баатар Т. Жангарч Ням хийгээд түүний хэлсэн жангарын хэв намба // «Баруун Монгол судлал» сэтгүүл. 2010. № 4. С. 104–111.
- Жамц Т. Ойрад жангарчид хийгээд тэдний жангар хайлах хэв намба // «Монгол хэл, утга зохиол» сэтгүүл. 1989. № 6. С. 32–42.
- Жамц Т. Шинжаанд «Жангар»-ыг хайн шинжилж байгаа нь // «Монгол хэл, утга зохиол» сэтгүүл. 1985. № 3. С. 84–89.
- Жамц Т. Шинжааны ойрад монголын баатарлаг тууль «Жангар»-ын тархалт ба түүний хадгалалтын тойм байдал // «Үүрийн цолмон» сэтгүүл. 1985. № 1. С. 353–369.
- Надмай Т. Жангарч Л. Пүрэвийн дөхөм танилцуулга // «Хэл ба орчуулга» сэтгүүл. 1999. № 2. С. 46–47.
- Нарс. Баянголын орчин үеийн жангарчдыг туршин өгүүлэх нь // «Ойрадын судлал» сэтгүүл. 1999. № 2. С. 16–24.
- Ринчендорж Ж. Шинжааны жангар хийгээд жангарчдын тухай // «Үүрийн цолмон» сэтгүүл. 1984. № 4. С. 14–36.
- Ринчендорж Ж. Шинжааны жангар хийгээд жангарчдын тухай // Өвөрмонголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 1984. № 2. С. 23–48.
- Таяа Д. 2011 оны Дундад улсын Монгол тууль судлалын ерөнхий тоочил // «Дундад улсын монгол судлал» сэтгүүл. 2012. № 6. С. 21–27.
- Таяа Д. ХХ зууны үеийн Шинжааны ойрдын жангарчдын эгнээ // «Үүрийн цолмон» сэтгүүл. 2003. № 5. С. 85–91.
- Таяа Д. Шинжааны жангарчдын «Жангар» хайлах, хэлбэр маягийн тухай // «Ойрадын судлал» сэтгүүл. 2006. № 4. С. 108–113.
- Таяа Д. Шинжааны ойрад жангарчдын хэв намбын асуудалд // «Хэл ба орчуулга» сэтгүүл. 2005. № 1. С. 37–45.

- Шагай Д. Жангарын туулийг цуглуулах явцад хувь нэмрээ өргөсөн жангарчдын тухай өгүүлэх нь // «Хэл ба орчуулга» сэтгүүл. 1999. № 2. С. 48–53.
- 特·贾木查著 汪仲英、乔伦夫译：《蒙古族英雄史诗〈江格尔〉调查报告》，《新疆民族文学》，1982年第3期 С. 62–68.
- （蒙古族）特·贾木查：《〈江格尔〉在卫拉特蒙古中的蕴藏情况》，《民族文学研究》，1986年第3期 С. 36–39.
- 扎格尔：《中国〈江格尔〉版本传承及研究状况评述》，《内蒙古师范大学学报（哲学社会科学版）》1994年第1期 С. 71–76.
- References**
- Altan Kh. *Torguud zhangarchdyn tukhay dōkhōm ögüülekh n'* [Brief data about Torgut Jangar-tellers]. «*Shinzhaany ödriyn sonin*» [Xinjiang Newspaper], 1998, March, 3 p. (In Mong.).
- Altan Kh. *Torguud zhangarchdyn tukhay taniltuulga* [Getting acquainted with Torgut Jangar-tellers]. «*Övörmongolyn niygmiyn shinzhlekh ukhaan*» setgüül [Social Sciences in Inner Mongolia journal], 1998, No. 6, pp. 48–50 (In Mong.).
- Baatar T. *Zhangarch Nyam khiygeed tüüniy khelsen zhangaryn khev namba* [Jangar-teller Nyam and his style of performance]. «*Baruun Mongol sudlal*» setgüül [Western Mongolian Studies journal], 2010, No. 4, pp. 104–111 (In Mong.).
- Zhamts T. *Oyrad zhangarchid khiygeed tedniy zhangar khaylakh khev namba* [Oirat Jangar-tellers and their individual styles of performance]. «*Mongol khel, utga zokhiol*» setgüül [The Mongolian Language and Literature journal], 1989, No. 6, pp. 32–42 (In Mong.).
- Zhamts T. *Shinzhaand «Zhangar»-yg khayn shinzhilzh bayгаа n'* [Jangar studies in Xinjiang]. «*Mongol khel, utga zokhiol*» setgüül [The Mongolian Language and Literature journal], 1985, No. 3, pp. 84–89 (In Mong.).
- Zhamts T. *Shinzhaany oyrad mongolyn baatarlag tuul' «Zhangar»-yn tarkhalt ba tüüniy khadgalaltyn toym baydal* [Data about the dispersion of the Xinjiang Mongolian heroic epic of Jangar and its traditions]. «*Üüriyn tsolmon*» setgüül [The Morning Star journal], 1985, No. 1, pp. 353–369 (In Mong.).
- Nadmay T. *Zhangarch L. Püreviyn dōkhōm taniltuulga* [A brief sketch about Jangar-teller Purev]. «*Khel ba orchuulga*» setgüül [Language and Translation journal], 1999, No. 2, pp. 46–47 (In Mong.).
- Nars. *Bayangolyn orchin yeiyn zhangarchdygturshin ögüülekh n'* [Description of contemporary Jangar-tellers of Bayangol]. «*Oyradyn sudlal*» setgüül [Oirat Studies journal], 1999, No. 2, pp. 16–24 (In Mong.).
- Rinchendorzh Zh. *Shinzhaany zhangar khiygeed zhangarchdyn tukhay* [About the Jangar of Xinjiang and its tellers]. «*Üüriyn tsolmon*» setgüül [The Morning Star journal], 1984, No. 4, pp. 14–36 (In Mong.).
- Rinchendorzh Zh. *Shinzhaany zhangar khiygeed zhangarchdyn tukhay* [About the Jangar of Xinjiang and its tellers]. *Övörmongolyn bagshiyn ikh surguuliyn erdem shinzhilgeeni setgüül* [Journal of Inner Mongolia Pedagogical University], 1984, No. 2, pp. 23–48 (In Mong.).
- Tayaa D. *2011 ony Dundad ulsyn Mongol tuul' sudlalyn erönkhiy toochil* [General data about studies of the Mongolian epic tradition in China]. «*Dundad ulsyn mongol sudlal*» setgüül [Mongol Studies in China], 2012, No. 6, pp. 21–27 (In Mong.).
- Tayaa D. *XX зууны yeiyn Shinzhaany oyrдын zhangarchdyn egnee* [The 20th century Oirat Jangar-tellers of Xinjiang]. «*Üüriyn tsolmon*» setgüül [The Morning Star journal], 2003, No. 5, pp. 85–91 (In Mong.).
- Tayaa D. *Shinzhaany zhangarchdyn «Zhangar» khaylakh, khelber mayagiyn tukhay* [Jangar-tellers of Xinjiang: styles of performance]. «*Oyradyn sudlal*» setgüül [Oirat Studies journal], 2006, No. 4, pp. 108–113 (In Mong.).
- Tayaa D. *Shinzhaany oyrad zhangarchdyn khev nambyn asuudald* [Jangar-tellers of Xinjiang: styles of performance revisited]. «*Khel ba orchuulga*» setgüül [Language and Translation journal], 2005, No. 1, pp. 37–45 (In Mong.).
- Shagay D. *Zhangaryn tuuliyg tsugluulakh yavtsad khuv' nemree örgösön zhangarchdyn tukhay ögüülekh n'* [About Jangar-tellers who contributed to the process of collecting the Epic]. «*Khel ba orchuulga*» setgüül [Language and Translation journal], 1999, No. 2, pp. 48–53 (In Mong.).
- 贾木查著汪仲英、乔伦夫译：《蒙古族英雄史诗〈江格尔〉调查报告》，《新疆民族文学》，1982年第3期 С. 62–68.
- （蒙古族）特·贾木查：《〈江格尔〉在卫拉特蒙古中的蕴藏情况》，《民族文学研究》，1986年第3期 С. 36–39.
- 扎格尔：《中国〈江格尔〉版本传承及研究状况评述》，《内蒙古师范大学学报（哲学社会科学版）》1994年第1期 С. 71–76.

Общий обзор исследований баянгольского «Джангара» (1980-е гг. – начало XXI в.)
Баянталын Тэргэл¹

¹ магистрант, Институт монголоведения, Университет Внутренней Монголии (г.Хух-хото, КНР). E-mail: Ananda1015@163.com

Аннотация. Цель данной статьи — представить исследования, посвященные изучению героического эпоса «Джангар», бытующего среди населения Баянгол-Монгольского автономного округа Синьцзяна, и изложить их основные идеи. С этой целью автор поставил следующие задачи: во-первых, рассмотреть вопрос о джангарчи (исполнителях «Джангара») и особенностях изучения героического эпоса «Джангар», в том числе на материале баянгольских монголов (ойратов); во-вторых, осветить методику исследования особенностей исполнения и исполнительского мастерства джангарчи; в-третьих, сопоставить точки зрения исследователей, изучавших сохранившуюся традицию эпоса «Джангар».

Сопоставительный анализ трудов ученых, посвятивших свои работы эпосу «Джангар», традиция исполнения которого до сегодняшнего дня сохраняется и передается среди синьцзянских ойратов, позволяет говорить о том, в какой степени сохранилась среди населения Баянгол-Монгольского автономного округа в СУАР КНР традиция исполнения «Джангара», а также в какой степени получила освещение эта проблема в рассматриваемых исследованиях.

Принято считать, что традиция исполнения эпоса «Джангар» бытует и передается там, где расселены монгольские народы, при этом в каждом регионе (*нутаг*) исполняется по-разному. В силу этого изучение традиции «Джангара» у синьцзянских баянгольцев, освещение истории ее изучения в трудах ученых представляется важным направлением эпосоведения.

Ключевые слова: ойраты, Синьцзян, Баянгол, джангароведение